

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2024.05.27

Чойр

ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Эх үүсвэр	Суурь түвшин /суурь он- 2023	2024 он		Хэрэгжилтийн явц, үнэлгээ
					Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	
1	2	3	4	5	6	7	8
2.7.Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.	35	2.7.1.Хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ.	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо /шинээр томилогдсон 4 албан хаагч/ Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо 8 Нийт өрхөд эзлэх хувь 50%	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо /шинээр томилогдсон албан хаагч/ Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо - Нийт өрхөд эзлэх хувь	-	Монгол Улсын Засгийн газрын 2007 оны “Угийн бичиг хөтлөх журам батлах тухай” 257 дугаар тогтоол, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хүрээнд иргэдэд угийн бичгийн талаар мэдлэг, ойлголтыг өгч, угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоог нэмэгдүүлэх ажлыг хүрээнд угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдолын талаар сургалтыг аймгийн насан туршийн боловсролын газраас багш урьж угийн бичиг хөтлөх сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж 10 албан хаагч хамрагдсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Монгол бичгийн хэрэглээг олон нийтийн хүртээл болгож, хос бичигтэн болгох, үндэсний өв соёлоо хөгжүүлэх, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “ Монгол бичиг мину-XXI” говийн бүсийн олимпиадад тус байгууллагаас 5 алба хаагч амжилттай оролцсон. Хэрэгжилт 70%
3.4.Биеийн тамир, спортын үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлнэ.	45	3.4.1.Нийтийн биеийн тамирыг дэмжиж эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, иргэдийн хамрах хувийг	Хамтын сан	Арга хэмжээний тоо 5 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100 Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	Арга хэмжээний тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	-	2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Өвлийн агаар өлчир бие” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 6 төрөлд тэмцээнд амжилттай оролцсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53-р зарлиг Засгийн газрын 05 тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Биеийн тамир спортын газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс зохион байгуулж буй “Бие бялдарын түвшин тогтоох сорил, илүүдэл жин таргалалт”-ын судалгаанд байгууллагын 13 алба хаагчийг хамруулсан. Мөн газраас хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүл аж

		нэмэгдүүлнэ.		/шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулна. /	/шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулна. /	төрөх дадал хэвшил төлөвшүүлэх “ Өглөөний агаар-идэвхтэй хөдөлгөөн” бүх нийтийн арга хэмжээнд 3 удаа 6 алба хаагч хамрагдсан. Мөн аймгийн төрийн албаны зөвлөлөөс 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан Сагсан бөмбөг 3х3, Волейбол, Олс таталтын тэмцээнд байгууллагын спорт хамтлаг хариуцан алба хаагчдыг хамруулсан. Хэрэгжилт 100%
5.1.Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.	63	5.1.1.Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, албан хаагчдыг мэргэшүүлэн, төрийн үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцлийг сайжруулж, шаардлагатай барилга, дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	БТ	Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо-9  Сургалтад хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдын тоо-  Шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангагдсан эсэх	Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо-  Сургалтад хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдын тоо /давхардсан тоогоор /  Шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангагдсан эсэх-	-  Энэ оны 05 сарын байдлаар сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. Зохион байгуулсан дотоод сургалт “Хортой хүн” түүний сөрөг үр, дагавар, “Донор”-ын талаарх ерөнхий ойлголт түүний ач холбогдол, “Байгууллагын эмэгтэй алба хаагчдад сэтгэл зүйн чиглэл”-ийн, “Зөв хоололт”, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, хэм хэмжээ, эрх зүйн зохицуулалт, “Даатгал түүний ач холбогдол”, “Архив бичиг хэргийн бүрдэл”, “Малын шимэгдэгч өвчний талаархи ерөнхий мэдлэг олгох”, “PCR төхөөрөмжөөр онош тогтоох арга зүй эзэмшүүлэх”, “Алба хаагчийн харилцаа хандлага” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 117 алба хаагч хамрагдсан байна. Дээд шатны байгууллага болон бусад газраас зохион байгуулсан МУИХ-ийн сонгууль-2024 он 2, Хүүхэд хамгааллын тухай, нийгмийн даатгалын багц хууль 8, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, Төрийн алба хаагчийн ёс зүй, харилцаа хандлага 14, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай” 1, “Мал амьтны вирусын гаралтай өвчинтэй тэмцэх арга хэмжээ, сайжруулах нь 6 , “Төрийн албаны ёс зүй” 14, Жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарын хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгийн тухай” 8 , “Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл”ийг чадвахжуулах”, “Төрийн үйлчилгээний цахим системүүдийн танилцуулга, ERP, цахим аймгийн бодлогын барим

						<p>бичигийг боловсруулах зөвлөх үйлчилгээ”, “Digital first1”, ICP мэдээллийн аюулгүй байдлын тухай” 1, “Аудит бидний амьдралд” УМЭАЦТЛабораторийн Онош зүйчдийн зөвлөлөөс зохион байгуулсан .”Байгаль орчноос шалтгаалах эмгэг хүнд металлын хордлого”, “Биохими, гематологийн шинжилгээ” сэдэвт цахим сургалтад 3 алба хаагч, “ Нян судлалын шинжилгээний арга”, “Паразит өвчний шинжилгээнд сорьц авах ,”Хавсрага холбох арга үр дүн, хавсрагын таниц тогтоох” 2, Авермиктний бүлгийн эмийн үлдэгдэл тодорхойлох ЭЛИЗА арга, Цөмийн цацрагийн тухай, шинжилгээ,Ур чадварын талаарх танилцуулга мэдээлэл хийх цахим сургалтад 2 алба хаагч, Мал, амьтны вирусийн гаралтай өвчинтэй тэмцэх арга хэмжээг сайжруулах нь” үндэсний хэлэлцүүлэгт 3 албан хаагч тус тус хамрагдсан ба энэ оны 05 сарын байдлаар 16 сургалтад давхардсан тоогоор 156 алба хаагчийг хамруулан эрх зүйн мэдлэгийг дээшлүүлээд байна.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	
<p>5.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, гадаад хамтын ажиллагаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх</p>	64	<p>5.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж эхлэнэ.</p>	-	<p>Хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагын тоо -0</p> <p>Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн чиг үүргийн тоо -0</p>	<p>Хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагын тоо</p> <p>Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн чиг үүргийн тоо</p>	-	<p>Сумын Засаг дарга, Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хоорондын гурвалсан гэрээг жил бүр байгуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг 3, улсын төсвөөс санхүүжүүлдэг 6 нийт 9 төрлийн дархлаажуулалтыг мөн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчид хоорондын гэрээгээр паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ болох тарилга, туулга, угаалга, боловсруулалт, ужиг халдварт өвчнөөс сэргийлэх 3 төрлийн дархлаажуулалтыг хувийн хэвшлийн нэгжээр гүйцэтгүүлж, технологийн мөрдөлтөнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажилладаг. Мал эмнэлгийн хавар, намрын технологит арга хэмжээг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад ажиллаж буй 6 МЭҮН-ээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 21.3 мян.тол малыг мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулсан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>

	67	5.3.2.Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг өргөжүүлнэ.	БТ	ХУР, ДАН систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо - Тоон гарын үсэг нэвтрүүлсэн байгууллагын тоо 1	ХУР, ДАН систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо - Тоон гарын үсэг нэвтрүүлсэн байгууллагын тоо	-	Улсын хэмжээнд нэвтрүүлж буй тоон гарын үсгийг 2022 онд нэвтрүүлсэн ба байгууллагын 14 албан хаагч иргэний тоон гарын үсэг нээлгэсэн. Мөн байгууллагын удирдлага тоон гарын үсэг нээлгэж, шаардлагатай тохиолдолд хэрэглэж хэвшсэн.  Хэрэгжилт 100%
5.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийт мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг цахимаар авах орчин нөхцлийг бүрдүүлнэ.	68	5.3.3. Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангуулж, дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэн тусгай зөвшөөрөл, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ.	-	Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100 Дотоод удирдлагын ERF систем нэвтрүүлсэн байгууллагын тоо 1 Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байгаа байгууллагын тоо 0 Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь 100	Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Дотоод удирдлагын ERF систем нэвтрүүлсэн байгууллагын тоо Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байгаа байгууллагын тоо Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	-	-Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах талаар жил бүр ажил зохион байгуулж хэвшсэн ба 2024 оны 5 сарын байдлаар нийт 36 ажил, арга хэмжээний мэдээ, мэдээллийг Мал эмнэлгийн газрын цахим хуудас, пейж хуудсанд байршуулсан. Мөн мал, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд олгох мал эмнэлгийн гэрчилгээ олголтыг цахимжуулсан ба мал эмнэлгийн газар, тасаг, нэгжийн эмч нар ашиглаж хэвшсэн. Энэ нь гарал үүслийг тодорхойлох, мөрдөн мөшгих тогтолцоог хэрэгжүүлэх, малын хулгайг илрүүлэх үр дүнтэй ажил болж чадсан. -Байгууллагын дотоод удирдлагын ERP системд байгууллага, ажлын байр, албан хаагчдын мэдээлэл болон хандах зохицуулалтыг 2021 онд бүрэн хийж, төрийн байгууллагуудын албан тушаалтнуудтай холбогдож, тайлан, мэдээ хүргүүлэх, цаг үеийн асуудлаар цаг алдалгүй, түргэн шуурхай мэдээлэл солилцох боломжоор бүрэн хангасан. 2022 оноос ERP системийн ашиглалтыг сайжруулж, байгууллагаас гарч буй албан бичгийг системээр дамжуулан бусад байгууллагад хүргэж хэвшсэн ба ашиглалтын тасралтгүй байдлыг хангасан. - Тус байгууллагад эхний хагас жилийн байдлаар 9 өргөдөл гомдол ирсэн ба хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100%. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг

							цахим бус хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэж байна. Хэрэгжилт 90%
5.4.Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлж, үйл ажиллагаа, үр дүнг сайжруулна.	69	5.4.1.Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ.	-	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо 6 Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн эсэх	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо 0 Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн эсэх	-	Засгийн газрын 2018 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн газар байгуулагдсан ба Хүнс, хөдөө аж ахуйн газрын байранд төрийн үйлчилгээ үзүүлж байна. Өөрт бүртгэлтэй ажлын байргүй тул чанарын менежментийн тогтолцоо ISO MNS90012016 нэвтрүүлэх боломж нөхцөл бүрдээгүй байна. ХТБ
	70	5.4.2.Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	-	Мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо 1  Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо ТЗ болон ТҮ албан хаагчдын ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо 1	Мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо ТЗ болон ТҮ албан хаагчдын ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо -	-	Энэ оны 05 дугаар сарын байдлаар дотоод сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 80%. Дотоод сургалтыг 12 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 117 албан хаагч, дээд шатны байгууллага болон бусад газраас зохион байгуулсан 16 сургалтад давхардсан тоогоор 156 алба хаагч, нийт 28 сургалтад давхардсан тоогоор 273 албан хаагчийг хамруулан эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.  Хэрэгжилт 100%
	71	5.4.3.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг ханган, тогтвортой ажиллах, төрийн албанд шатлан дэвших зарчмыг	БТ	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 80	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -	БТ	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны ажлын төлөвлөгөөг 7 арга хэмжээгээр боловсруулж баталсан ба эхний хагас жилийн хэрэгжилт 95.2%. 1.Байгууллагын дотоод нэгж буюу ЗСА, МАЭМА-ны даргад шинээр томилогдсон 2 албан хаагчийг “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан зөрчилгүй томилсон. 2.Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1 орон сууцанд бусад орон нутгаас шилжин ажиллаж буй 1

		хэрэгжүүлнэ.					<p>малын эмчийг суулгаж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>3.Нарийн мэргэжлийн малын эмчийн сул орон тоог нөхөх зорилгоор АЗДТГ-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрт 5 албан хаагчийг орон сууцанд хамруулахаар өргөдөл хүргүүлсэн.</p> <p>4.МЭГ-ын контор, лабораторийн барилга байгууламжийг шинээр барьж байгуулах асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүсэлт гаргаж хариу авсан.</p> <p>5.Байгууллагын 4 албан хаагчид нийт 800,000 төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн. Мөн Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор 4 албан хаагчид 28,360,809 төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 100%</p>
5.6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэн нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	73	5.6.1.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Албан хаагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо 1 Хамрагдсан албан хаагчдын тоо 10	Албан хаагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо - Хамрагдсан албан хаагчдын тоо -	-	<p>Тус байгууллагад ХАСХОМ мэдүүлэх эрх бүхий 5 албан хаагч байгаа ба 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлж, тайланг цахимаар ерөнхий газарт хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөл болон МЭЭГ-аас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага анхаарах асуудал” Төрийн албаны тухай хууль” зэрэг сэдэвт 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 24 албан хаагчийг хамруулсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 70%</p>
8.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг	116	8.3.4. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч, мал амьтны	УТХО, ОНТ	Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-78.2 мян.тол Гоц халдварт өвчнөөс сэргийлэх	Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо- 74.7 мян.тол Гоц халдварт	42.7 сая.төг	<p>-Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн дархлаажуулалтад 68.0 мян.тол мал хамруулахаас 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 9.8 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 14.4%.</p> <p>-Мал, амьтны гоц халдварт шүлхийгээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны</p>

эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.		гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, нийтийн эрүүл мэндийг хамгаална.		арга хэмжээнд хамруулах малын тоо- 627.2 мян.тол Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-91.1 мян.тол  Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-396.8 мян.тол	өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо- 668.8 мян.тол  Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо- 101 мян.тол Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо- 458.3 мян.тол	өдрийн А/175 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Тус арга хэмжээний хүрээнд МЭЭГ-аас 16000 тун вакциныг хүлээн авч МЭГ-ын нөөцөд байсан 1100 тун нийт 17100 тун вакциныг 3 сумын 5 МЭҮН-д хуваарилж хүргүүлсэн. Дархлаажуулалт 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлнэ. <b>Тайлбар:Төлөвлөгдсөний дагуу гүйцэтгэл нь 100% байх бүрэн боломжтой.</b> -Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд эхний хагас жилд 139.5 мян.тол мал хамруулахаас 11.5 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 8.2%. <b>Тайлбар:Зудын гамшгийн улмаас хорогдсон 111,551 толгой малыг булж устгасан ба малын тоо, малчин өрхийн санхүү, сэтгэл зүйн байдалд эрс өөрчлөлт орсон нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.</b> Хэрэгжилт 50%
---	--	---	--	--	---	--

#### БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үүнээс				Хэрэгжилтийг тооцох боломжгүй	Биелэлтийн хувь
			Үр дүнтэй /90-100/	Тодорхой үр дүнд хүрсэн /60-89/	Эрчимжүүлэх шаардлагатай /31-59/	Үр дүнгүй /0-30/		
1	8	11	100%	70%	50%	0%	1	89%
			7	2	1	-		

#### МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР